

ДУНДГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТОДРУУЛГА ТАЙЛАН

2023.08.02

Мандалговь хот

1.Нийт төсвийн талаар: Тус аймгийн 2024 оны төсвийн төсөлд нийт 8,739,796.1 мянган төгрөгийн санал тусгагдлаа. Үүний үндсэн үйл ажиллагаа(80101) хөтөлбөрт 8,068,665.0, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал (80802) хөтөлбөрт 265,997.0, уран бүтээлийн зардлын төсөвт (80214) хөтөлбөрт 405,135.0 мянган төгрөг.

2.Цалин, орон тооны талаар: Нийт төсвийн 7,426,403.0 мянган төгрөг буюу 84.9 хувь нь цалин, шимтгэлийн зардлын төсөв байна. 18 байгууллагын нийт 365 орон тоотой ажиллахаар тусгалаа. Соёлын сайд, Сангийн сайдын 2022 оны 12 сарын 23 ны өдрийн А/429/259 тоот хамтарсан тушаалын хүрээнд 14 сумын соёлын төвийн орон тоо, цалинг нэмэгдүүллээ. Төв халхын дуулалт жүжгийн театр орон тоо нэмээгүй. Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрт 16, музейд 10, аймгийн төв номын санд 2 орон тоо шинээр нэмэгдүүлэх санал ирснийг саналаар нь тусгалаа. Сумдын соёлын төв дээр 0.5 орон тоон дээр тухайн албан тушаалын үндсэн цалингаас ажил хавсарсны 40 хувиар бодож, бусад нэмэгдэл тооцоогүй.

3. Бараа үйлчилгээний зардлын талаар: Хоёр сайдын хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтын хүрээнд хүчин чадал(суудлын тоо, сумын төвөөс аймгийн төв хүртэлх зайн индексээр суурь зардлыг тооцлоо. Үүнээс томилолтын зардал, эд хогшлын зардлыг ирүүлсэн саналаар, эд хогшлын зардал төсөвлөж ирүүлээгүй байгууллага дээр 5 сая төгрөг тусгасан.

4. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын талаар: Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын төсвийг сумдын соёлын төвүүдэд сайдын хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар, мэргэжлийн урлагийн 4 байгууллагын хувьд ирүүлсэн саналаар. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн төсвийг МУ-ын 2019 оны 01 сарын 09ны өдрийн "журам батлах тухай" 7 дугаар тогтоолын дагуу тооцсон. 2024 онд 7 тэтгэвэр авагчийн 148,725.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилсны тэтгэмжийг Соёлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9, МУ-ын засгийн газрын 2023 оны 05 сарын 17 ны өдрийн "журам батлах тухай" тогтоолын хүрээнд 12 албан хаагчийн 84,431.0 мянган төгрөг тусгалаа.

5. Уран бүтээлийн зардлын талаар: Мөн хамтарсан тушаалын дагуу сумдын соёлын төвүүдэд тус бүр 10 сая төгрөг, төвийн 4 байгууллагын хувьд ирүүлсэн саналаар нь төсөвлөлөө.